



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-3259  
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.03.25 № 298  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ Т

**ДАШИНЧИЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Д.ЛУТТӨМӨР ТАНАА**

ТАГ-аас танай сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд баталгаажуулах аудит хийсэн дүгнэлт, тайланг хүргүүлж байна.

Аудитаар 96,002.3 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж хүргүүллээ.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор бүрэн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана уу.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭ



006030355



## БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дашинчилэн сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2023/13/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Булган аймаг  
2023 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд  
Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ  
Утас: 7034-2580 Цахим хаяг: [Erdeneb@audit.gov.mn](mailto:Erdeneb@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол  
Утас: 7034-2716 Цахим хаяг: [enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:enkhtsoodolj@audit.gov.mn)

Аудитор: Д.Анхбаяр  
Утас: 7034-2495 Цахим хаяг: [Ankhubayard@audit.gov.mn](mailto:Ankhubayard@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	3
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	7
3.4.2 Авлага .....	9
3.4.6 Үндсэн хөрөнгө .....	10
3.4.7 Өр төлбөр .....	10
3.4.10 Засгийн газрын хувь оролцоо .....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
4.7.1 Завсрын аудитын талаар.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	15
5.3 Зөвлөмж.....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	16

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.03.25 № 297

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

ДАШИНЧИЛЭН СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Д.ЛУТТӨМӨР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дашинчилэн сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дашинчилэн сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг мөрдлөг болгосон байна. Дашинчилэн сумын эрхэм зорилго нь ардчилалыг бэхжүүлэх, НӨУБ-ыг төлөвшүүлэх, сумын нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн оролцоотой шийдвэрлэхэд тэдний идэвхи санаачлага нөөц боломжийг дайчлах замаар орон нутгийн тогтвортой тэнцвэрт хөгжлийг хангах зорилго дэвшүүлэн ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант 2022 онд 2021 оны IX/02 дугаар хуралдаанаар батлагдсан төсвийг 59,817.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. ОНХС-гийн төсөл

006020398

хэрэгжих хугацаанд нийт 15 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 12 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. Малын тоо толгойн албан татвараас хийгдэх ажлын гүйцэтгэл нийт 12 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 8 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад тусгай сангийн дансны бичилтийг НББББ-ыг мөрдөөгүй, авлагыг хугацаагаар нь богино болон урт хугацаат авлагаар ангилж, санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлээгүйгээс бодитой мэдээллээр хэрэглэгчдийг хангаж чадахгүй эрсдэл үүсч байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		797,385.30	587,624.40
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	365,450.10	279,366.90
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	92,426.20	120,917.00
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	339,509.00	187,340.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		3,857,882.30	1,061,695.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	3,857,882.30	1,061,695.20
39200	Биет хөрөнгө		3,788,139.30	1,051,325.70
39300	Биет бус хөрөнгө	13	69,743.00	10,369.50
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		4,655,267.50	1,649,319.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		3,028.50	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	3,028.50	-
41300	Өглөг	17а, 17б	3,028.50	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		4,652,239.00	1,649,319.60
51	Засгийн газрын хувь оролцоо		4,652,239.00	1,649,319.60
51100	Засгийн газрын оруулсан капитал		2,793,941.40	375,510.20
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		-	375,510.20
51200	Хуримтлагдсан үр дүн		328,361.00	959,651.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,529,936.60	314,157.70
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		4,655,267.50	1,649,319.60

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		3,524,717.60	1,512,206.20
11	ТАТВАРЫН ОРЛОГО		178,444.10	344,972.60
110	Орлогын албан татвар		53,771.00	188,039.10
1100	Хувь хүний орлогын албан татвар		53,771.00	188,039.10
113	Хөрөнгийн албан татвар		89,441.70	96,385.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж		35,231.30	60,548.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	500,298.90	382,937.40
120	Нийтлэг татварын бус орлого		499,298.90	381,937.40
121	Хөрөнгийн орлого		1,000.00	1,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,845,974.60	784,296.20
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	3,564,334.00	1,439,815.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,564,334.00	1,439,815.70

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,249,783.2 0	1,089,631.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,564,266.0 0	330,634.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	212,560.80	40,678.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	418,062.70	406,657.20
2104	Хангамж, бараа материалын зардал	74,912.40	37,393.60
2105	Нормативт зардал	456,551.30	909.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,701.50	43,001.30
2107	Томилолт, зочны зардал	3,206.00	5,338.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,843.10	1,474.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	488,679.30	223,544.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	314,550.80	350,184.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)- (II)	(39,616.40)	72,390.50
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	17,576.00	12,845.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	116,852.00	3,088,476.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(138,892.40)	(3,003,240.50 )

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөгөөр/				
Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2021 оны 12- р сарын 31	2022 оны 12- р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		3,264,246.60	1,350,311.60
11	ТАТВАРЫН ОРЛОГО		178,444.10	344,972.60
110	Орлогын албан татвар		53,771.00	188,039.10
1100	Хувь хүний орлогын албан татвар		53,771.00	188,039.10
113	Хөрөнгийн албан татвар		89,441.70	96,385.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж		35,231.30	60,548.20
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		12,973.80	9,342.60
1181	Газрын төлбөр		22,052.50	50,205.60
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		205.00	1,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		239,827.90	216,562.80
120	Нийтлэг татварын бус орлого		238,827.90	215,562.80
121	Хөрөнгийн орлого		1,000.00	1,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,845,974.60	788,776.20
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,969,041.30	935,061.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,969,041.30	935,061.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,658,977.10	930,056.20

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,570,439.00	329,588.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	205,937.70	40,678.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	414,569.20	415,131.20
2104	Хангамж, бараа материалын зардал	67,449.10	28,512.00
2105	Нормативт зардал	209,629.50	796.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,124.30	38,974.70
2107	Томилолт, зочны зардал	3,178.00	5,338.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,943.10	1,474.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	164,707.10	69,562.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	310,064.20	5,005.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	295,205.30	415,249.90
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	74,175.90	371,607.40
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	74,175.90	371,607.40
2200	Дотоод эх үүсвэрээр	74,175.90	371,607.40
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(74,175.90)	(371,607.40)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(36,400.40)	(129,725.60)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	36,400.40	129,725.60
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	184,629.00	(86,083.10)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	180,821.10	365,450.10
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	365,450.10	279,366.90

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Тайлангийн үзүүлэлт	/ мянган төгрөгөөр/	
		Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,791,131.40	4,791,131.40
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,791,131.40	4,791,131.40
3	Тайлант үеийн үр дүн	(138,892.40)	(138,892.40)
4	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,652,239.00	4,652,239.00
5	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,652,239.00	4,652,239.00
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	321.10	321.10
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,652,560.10	4,652,560.10
8	Тайлант үеийн үр дүн	(3,003,240.50)	(3,003,240.50)
9	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,649,319.60	1,649,319.60

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
21	УРСГАЛ ЗАРДАЛ	946,334.80	922,783.09	23,551.71	97.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	944,034.80	920,485.09	23,549.71	97.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	336,299.10	329,588.02	6,711.08	98.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,998.90	40,678.10	1,320.80	96.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	408,124.40	401,411.15	6,713.25	98.36
2104	Хангамж, бараа материалын зардал	28,640.60	28,512.02	128.58	99.55
2105	Нормативт зардал	800.00	796.80	3.20	99.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,600.00	61,245.40	2,354.60	96.30
2107	Томилолт, зочны зардал	7,351.00	5,338.00	2,013.00	72.62
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,820.80	1,474.92	345.88	81.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,400.00	51,440.69	3,959.31	92.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,300.00	2,298.00	2.00	99.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,300.00	2,298.00	2.00	99.91
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	556,052.30	346,136.74	209,915.56	62.25
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	192,860.00	129,725.60	63,134.40	67.26
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,223,640.00	1,251,570.36	(27,930.36)	102.28
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	471,607.10	181,674.75	289,932.35	38.52
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	92	52	40	56.5
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	45	25	20	55.5
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	45	25	20	55.5

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	35,082.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	35,082.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	35,041.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,720.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,321.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40.30
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	40.30
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	35,041.84
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,041.84
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	(40.30)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	40.30

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дашинчилэн сум эрхэм зорилгоо “Ардчиллыг бэхжүүлэх, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг төлөвшүүлэх, сумын нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлыг иргэдийн оролцоотой шийдвэрлэхэд тэдний идэвх санаачилга нөөц боломжийг дайчлах замаар орон нутгийн тогтвортой тэнцвэрт хөгжлийг хангах” зорилтыг дэвшүүлэн, үйл ажиллагааны чиглэлээ дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ✚ Засгийн газрын бодлого шийдвэрийг сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулан тайлагнах,
- ✚ Төрийн хууль тогтоомжийг сурталчлах хэрэгжүүлэх,
- ✚ Сумын хүн ам, ХХАА-н үйлдвэрлэл, үйлчилгээний бүртгэл судалгааг хөтөлж, дээд шатны байгууллагыг мэдээ мэдээллээр хангах,
- ✚ Сумын хөгжлийн хөтөлбөр, Засаг даргын Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа Төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэж, төрийн албаны стандартыг хангахад гол анхаарлаа чиглүүлэн ажиллах.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (4 удаа)
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолд оруулсан нэмэлт өөрчлөлт,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Санхүүгийн хяналт аудитын алба 2022 онд Хангал сумын Засаг даргын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийгээгүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дашинчилэн сумын Засаг дарга нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дашинчилэн сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр тушаалаар батлагдсан бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,750,795.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,739,371.9 мянган төгрөгөөр буюу 49.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	365,450.10	279,366.90	(86,083.20)
Авлага	92,426.20	120,917.00	28,490.80
Бараа материал	339,509.00	187,340.50	(152,168.50)
Үндсэн хөрөнгө	3,857,882.20	1,061,695.20	(2,796,187.00)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,655,267.50</b>	<b>1,649,319.60</b>	<b>(3,005,947.90)</b>
Өр төлбөр	3,028.50	-	(3,028.50)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,652,239.00	1,649,319.60	(3,002,919.40)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>4,655,267.50</b>	<b>1,649,319.60</b>	<b>(3,005,947.90)</b>

Дээрх хүснэгтээс харахад санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс нөлөө бүхий буюу материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Материаллаг өөрчлөлт гарсан шалтгаан нь Монгол Улсын засгийн газрын 2022 оны 131 дүгээр тогтоолоор сургуулийн өмнөх боловсролын өмнөх болон бага дунд боловсролын боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч нь Боловсролын ерөнхий газрын дарга байхаар батлагдсан, Мөн 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн “төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Төсвийн тухай хуульд өөрчлөлт орсноос нөлөөлсөн байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагч аймгийн Засаг дарга байсныг Төсвийн тухай хуулийн 2022 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн өөрчлөлтөөр хүчингүй болгосонтой холбоотой байна.

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны оны эхний үлдэгдэл 365,409.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 279,366.9 мянган төгрөг болж, 86,083.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2. Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Төрийн сангийн харилцах	365,409.80	279,366.90	(86,042.90)	100.0
Нэмэлт санхүүжилтийн харилцах	40.3	-	(40.30)	-
<b>Дүн</b>	<b>365,450.10</b>	<b>279,366.90</b>	<b>(86,083.20)</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Дашинчилэн сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 2,856.8 мянган төгрөг буюу 1.0 хувийг Байгаль хамгаалах сан, 32,357.3 мянган төгрөг буюу 11.6 хувийг Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, 110,279.5 мянган төгрөг буюу 39.5 хувийг Хоршоо хөгжүүлэх сан, 6,495.9 мянган буюу 2.3 хувийг Орон нутгийн ерөнхий орлого, 127,377.4 мянган төгрөг буюу 45.6 хувийг тус тус эзэлж байна.

#### 3.4.2 Авлага

Авлага дансны оны эхний үлдэгдэл 92,426.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 120,917.0 мянган төгрөг болж, 28,490.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Авлагын дансны үлдэгдэл

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажиллагчтай холбогдсон авлага	-	400.00	400.00	0.3
Байгууллагаас авах авлага	4,480.00	-	(4,480.00)	-
Хувь хүмүүсээс авах авлага	87,946.20	120,517.00	32,570.80	99.7
<b>Дүн</b>	<b>92,426.20</b>	<b>120,917.00</b>	<b>28,490.80</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Дашинчилэн сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 8,660.0 мянган төгрөг буюу 7.2 хувийг Жижиг дунд үйлдвэрлэлийг дамжих сан, 400.0 мянган төгрөг буюу 0.3 хувийг сумын ЗДТГ, 111,857.0 мянган төгрөг буюу 92.5 хувийг Хоршоо хөгжүүлэх сан тус тус эзэлж байна.

#### 3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данс эхний, эцсийн үлдэгдэлгүй байна.

#### 3.4.4 Бараа материал

Бараа материал дансны оны эхний үлдэгдэл 339,509.0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 187,340.5 мянган төгрөг болж, 120,495.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5. Бараа материал дансны үлдэгдэл

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Тусгай зориулалттай материал	29,651.60	-	-	-
Эм боох материал	11,014.00	-	(11,014.00)	-
Бичиг хэргийн материал	44,164.40	43,156.80	(1,007.60)	23.0
Аж ахуйн материал	161,630.80	72,805.40	(88,825.40)	38.9
Түлш, шатах тослох материал	4,908.40	1,357.30	(3,551.10)	0.7
Хүнсний материал	14,042.60	-	(14,042.60)	-
Бусад хангамжийн материал	39,211.20	37,156.00	(2,055.20)	19.8
Мал амьтад	34,886.00	32,865.00	-	17.5

<b>Дүн</b>	<b>339,509.00</b>	<b>187,340.50</b>	<b>(120,495.90)</b>	<b>100.0</b>
------------	-------------------	-------------------	---------------------	--------------

Эх сурвалж: Дашинчилэн сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 186,789.4 мянган төгрөг буюу 99.7 хувийг Засаг даргын тамгын газар, 551.0 мянган төгрөг буюу 0.3 хувийг Иргэдийн төлөөлөгчдийн хурал тус тус эзэлж байна.

### 3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны оны эхний үлдэгдэл 3,857,882.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1,061,695.2 мянган төгрөг болж, 2,796,187.1 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Барилга, байгууламж, орон сууц	4,921,506.20	631,114.60	(4,290,391.60)	59.4
Хуримтлагдсан элэгдэл	(2,238,982.60)	(328,572.50)	1,910,410.10	(30.9)
Авто-тээврийн хэрэгсэл	444,015.80	325,294.80	(118,721.00)	30.6
Хуримтлагдсан элэгдэл	(268,096.60)	(233,282.40)	34,814.20	(22.0)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	462,797.60	152,366.90	(310,430.70)	14.4
Хуримтлагдсан элэгдэл	(262,779.80)	(87,336.80)	175,443.00	(8.2)
Тавилга, аж ахуйн эд хогшил	320,241.00	56,877.00	(263,364.00)	5.4
Хуримтлагдсан элэгдэл	(174,326.60)	(32,075.10)	142,251.50	(3.0)
Зам, гүүрийн байгууламж	22,733.40	-	(22,733.40)	-
Хуримтлагдсан элэгдэл	(22,043.00)	-	22,043.00	-
Ном	31,467.80	-	(31,467.80)	-
Бусад үндсэн хөрөнгө	1,095,923.80	1,168,291.30	72,367.50	110.0
Хуримтлагдсан элэгдэл	(544,317.70)	(601,352.10)	(57,034.40)	(56.6)
Программ хангамж	12,765.50	4,350.00	(8,415.50)	0.4
Хуримтлагдсан элэгдэл	(6,710.50)	(2,412.50)	4,298.00	(0.2)
Бусад биет бус хөрөнгө	63,688.00	8,432.00	(55,256.00)	0.8
<b>Дүн</b>	<b>3,857,882.30</b>	<b>1,061,695.20</b>	<b>(2,796,187.10)</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Дашинчилэн сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 2,325,232.5 мянган төгрөг буюу 99.1 хувийг ЗДТГ, 21,494.0 мянган төгрөг буюу 0.9 хувийг Иргэдийн төлөөлөгчдийн хурал тус тус эзэлж байна.

### 3.4.7 Өр төлбөр

Өр төлбөр дансны оны эхний үлдэгдэл 3,028.5 мянган төгрөг, эцсийн үлдэгдэлгүй болж, 3,028.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Бараа үйлчилгээний зардлын өглөг	3,028.50	-	(3,028.50)	-
<b>Дүн</b>	<b>3,028.50</b>	<b>-</b>	<b>(3,028.50)</b>	<b>-</b>

Эх сурвалж: Дашинчилэн сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл өмнөх оны эрүүл мэндийн төвийн өглөг төлөгдөж, оны эцэст өр төлбөргүй ажилласан байна.

### 3.4.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 4,652,239.0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1,649,319.6 мянган төгрөг болж, 3,002,919.4 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №8. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл (мянган төгрөгөөр)*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,793,941.40	375,510.30	(2,418,431.10)	22.8
Хуримтлагдсан үр дүн	328,361.00	959,651.60	631,290.60	58.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,529,936.60	314,157.70	(1,215,778.90)	19.0
<b>Дүн</b>	<b>4,652,239.00</b>	<b>1,649,319.60</b>	<b>(3,002,919.40)</b>	<b>100.00</b>

*Эх сурвалж: Дашинчилэн сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Орон нутгийн хувь оролцоо дансны үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл 4,473.3 мянган төгрөг буюу 1.2 хувийг Иргэдийн төлөөлөгчдийн хурал, 371,036.8 мянган төгрөг буюу 98.8 хувийг Засаг даргын тамгын газар тус тус эзэлж байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,571,064.8 мянган зарлагыг 1,571,064.8 мянга төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Өргөн барьсан төсвийг орон нутгийн төсвийн орлогыг сумын ИТХ-ын “Төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2022 оны IX/02 дугаар хуралдааны тогтоолоор үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлогыг 106.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг шилжүүлгийг 8.2 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант 2022 онд 2021 оны V/02 дугаар хуралдаанаар батлагдсан төсвийг 184,167.1 мянга төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,296,596.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 400,0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,264,358.4 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 466.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,264,824.9 мянган төгрөг буюу 97,5% хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 31,771.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 7. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл (мянган төгрөгөөр)*

№	Хөтөлбөрийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	Хувь
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	69,977.00	65,343.00	4,634.00	93.4
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	492,615.10	473,697.39	18,917.71	96.2
3	Соёл урлаг	31,097.10	31,097.10	-	100.0
4	Сургуулийн өмнөх боловсрол	29,056.00	29,056.00	-	100.0
5	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	43,689.60	43,689.60	-	100.0
6	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	1,500.00	1,500.00	-	100.0
7	Ерөнхий боловсрол	278,400.00	278,400.00	-	100.0
<b>Нийт дүн</b>		<b>946,334.80</b>	<b>922,783.09</b>	<b>23,551.71</b>	<b>97.5</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Аудитын илрүүлэлт:**

- Сумын Засаг даргын тамгын газар анхан шатны баримтын иж бүрдэл дутуу Монгол шуудан болон иргэн, ААН-тэй холбоотой нийт 1910.4 мянган төгрөгийн 6-н ө баримтгүй гүйлгээ хийгдсэн, Засаг даргын нөөц хөрөнгийг пос төхөөрөмж авахад 897.6, теннисний ширээ авахад 1200.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, шатахуун зарцуулахдаа анхан шатны баримтын бүрдэлгүй, 7 сараас хойш шаардах хуудасгүй тус тус зарцуулсан байна.
- Сумын ИТХ Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу нийт 651.3 мянган төгрөгийн 23-н ө баримтгүй гүйлгээ хийгдсэн байна. /Монгол Шуудан ТӨХК 651300 төгрөг/, ИТХ-ын даргад 4 улирлын ажлын үр дүнгийн урамшууллыг ИТХ-ын нарийн бичгийн дарга эрх хэмжээ хэтрүүлж олгосон байна.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 35,041.8 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч эдийн засгийн ангиллын дагуу зарцуулалтын эрх нээлгэн зарцуулсан байна. Нэмэлт орлогын эх үүсвэрийг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 8. Нэмэлт санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалт

(мянган төгрөг)

№	Эх үүсвэр	Мөнгөн дүн
1	Булган мээж ОНӨХХК-аас төрөөс хариуцах усны төлбөрт	13,720.0
2	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас цэвэр орчин цэмцгэр булган аяны хог хаягдлын цэвэрлэх зардалд	1,500.0
3	Аймгийн Засаг даргын тамгын газраас оготно устгалын зардалд	15,678.1
4	Статистикийн хэлтсээс ХАА-н мал тооллогын зардал, ХАБХШХ-ийг тандах судалгааны зардалд	4,143.7
<b>Нийт дүн</b>		<b>35,041.8</b>

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант хугацаанд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дашинчилэн сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн орон нутгийн төсвийн орлого, шилэн дансттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Дашинчилэн сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 01/71 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь сумын ИТХ-ын хуралдаанаар батлагдсан нийт орлого ба тусламж санхүүжилтийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт батлагдсан орлого ба тусламж санхүүжилт 816,348.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 12,245.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 9,183.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна. Мөн хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

### **4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасан нийт 116 мэдээлэл байршуулахаас 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.7.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 01/332, 01/129, 2/333,01/228,03/230, 01/137 дугаар албан тоотоор тус тус ирүүлсэн.

*Хүснэгт 9. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	46,120.0	1	46,120.0	100.0
Албан шаардлага	2	105,650.0	1	105,650.0	50.0
Зөвлөмж	5	3,245.0	5	3,245.0	100.0
<b>Нийт дүн</b>	<b>8</b>	<b>155,015.0</b>	<b>7</b>	<b>155,015.0</b>	<b>87.5</b>

Сум хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудлаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй байна.

#### 4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын гүйцэтгэх цаг хугацааны нөөц, цар хүрээ хязгаарлагдмал байсан учраас дараагийн санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдлийг Орон нутгийн өмчийн газарт бүртгэлтэй хөрөнгөтэй тулгах, хөрөнгийн үлдэгдэлд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 96,002.3 мянган төгрөгийн 4 зөрчил<sup>1</sup> илэрснээс, албан тушаалтанд хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлж, 96,002.3 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

### 5.2 Албан шаардлага

1. Өмнөх оны ХХС-ийн санхүүгийн тайлангийн аудитаар ажил гүйлгээг бүртгэхдээ цаг хугацааны дараалал болон арга хэмжээг санхүүжүүлсэн ажил гүйлгээ бүрээр журналд бүртгээгүй, зээлдэгчийн хүү, алданги, авлагыг тухай бүр нь бүртгээгүй бөөн дүнгээр нь дансны бичилт хийж бүртгэсэн зөрчлийг таслан зогсоож, дахин давтан гаргахгүй анхаарч ажиллах албан шаардлыг биелүүлээгүй, аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр захирамжаар баталсан НБББББ-ийг мөрдөж санхүүгийн тайлангаа бэлтгээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" заасантай нийцээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Аудитаар өгөгдсөн албан шаардлагыг биелүүлээгүй, алдаа зөрчлийг арилгаагүй, зөрчлийг дахин давтан гаргасан тул хариуцлага тооцуулах албан шаардлагыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүллээ.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Орлогын данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Тайлант онд малын тоо, толгойн албан татвар 68,130.8 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Малын тоо толгойн албан татварын тухай 4 дүгээр зүйлийн 4.1-д "Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малыг өмчилж буй малчин, мал бүхий этгээд нь албан татвар төлөгч байна", 7 дугаар зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө" заалтыг хэрэгжүүлээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Сумын ИТХ-ын хуралдаанаар батлагдсан малын тоо толгойн албан татварын орлогыг бүрэн төвлөрүүлэн, хэрэгжилтийг хангаж ажиллах

#### 2. Зардлын данстай холбоотой асуудал

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*Илрүүлэлт:* Байгаль хамгаалах болон жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас анхан шатны баримтын иж бүрдэл дутуу нийт 27,871.5 мянган төгрөгийн и-баримтгүй 31 гүйлгээ хийгдсэн байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй", НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг хэрэгжүүлээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Бэлтгэн нийлүүлэгч талын борлуулалтын орлогыг баталгаажуулан и-баримтыг тухай бүр шаардаж, төлбөрийн баримтыг авч хэвших.

### 3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Шилэн дансны нэгдсэн системд 116 мэдээлэл байршуулахаас 10 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" заалтыг хэрэгжүүлээгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/сая төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ	-											
ТШЗ	-				-				-			
<b>Дүн</b>	-				-				-			

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		/сая төгрөгөөр/		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	3	96.0					2	96.0	1	1		
ТШЗ	6	15.3	1	0.4			4	14.9				
<b>Дүн</b>	<b>9</b>	<b>111.3</b>	<b>1</b>	<b>0.4</b>	-	-	<b>6</b>	<b>110.9</b>	<b>1</b>	<b>1</b>		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ТТЗ	1	-					1	-
ТШЗ	-	-			-	-		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>			<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ТТЗ								
ТШЗ								
<b>Дүн</b>	<b>-</b>	<b>-</b>			<b>-</b>	<b>-</b>		
<b>Нийт дүн</b>	<b>10</b>	<b>111.3</b>	<b>1</b>	<b>0.4</b>	<b>6</b>	<b>110.9</b>	<b>1</b>	<b>-</b>

ААБ 5.5: ДАШИНЧИЛЭН СУМЫН ТТЗ-ЫН АСУУДЛЫН БҮРТЭЛ

Хүснэгт А. Эрсдэлтэй АГАДУТ-ын үнэлсэн алдаа, зөрчлийг шийдвэрлэх  
2023.03.25

АД	АГАДУТ-ын дэд анги	Алдаа, зөрчлийн төвч утга	Мөнгөн дүн	Материаллаг засах эсэх	Үр өгөөжөөр тооцох эсэх	Стандарт заалт	Шалгуур үзүүлэлт		Алдаа зөрчлийн ангилал	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу	Гаргасан шийдэл
							Хууль тогтоомжийн заалт	Хууль тогтоомжийн заалт					
1	Орлого	Тайлант онд малын тоо, толгойн албан татвар 68,130.8 мянган төгрөгт дуту төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 4.1.2, 1-хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх, Малын тоо толгойн албан татварын тухай 4 дүгээр зүйлийн 4.1 Монгол Улсын нутаг байгаа малыг өмчилж буй малчин, мал бүхий этгээд нь албан татвар төлөгч байна" 7 дугаар зүйлийн 7.1 Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төлнө"-гэж заасантай нийцэхгүй байна.	68,130,799.00	Материаллаг	Тийм			Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 4.1.2, 1-хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх, Малын тоо толгойн албан татварын тухай 4 дүгээр зүйлийн 4.1 Монгол Улсын нутаг байгаа малыг өмчилж буй малчин, мал бүхий этгээд нь албан татвар төлөгч байна" 7 дугаар зүйлийн 7.1 Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төлнө"	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой	Албан татварыг бүрэн төвлөрүүлэн ажиллах зөвлөмж өгөх			Зөвлөмж
2	Зардал	БХСын, ЖДҮДСангийн анхан шатны баримтын иж бүрдэл дутуу нийт 27,871.5 мянган төгрөгийн 31-н ө баримтгүй гүйцлээ хийгдсэн байна.	27,871,550.00	Материаллаг	Тийм		Татварын ерөнхий хуулийн 28.5, НББ-ийн тухай хуулийн 13.7	Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой		Бэлтгэн нийлүүлэгч талын борлуулалтын орлогыг баталгаажуулан и-баримтыг тухай бүр шаардаж, төлбөрийн баримтыг авч хэвших зөвлөмж өгөх			Зөвлөмж
3	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20.5, Шилэн дансны мэдээлэл	Шилэн дансны нэгдсэн системд 116 мэдээлэл байршуулахаас 9 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлэлт байх" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.		Материаллаг	Үгүй		Шилэн дансны тухай хуулийн 4.1.1, 4.1.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20.5	Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой		Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж өгөх			Зөвлөмж
			Нийт дүн				96,002,349.00						

Бэлтгэсэн: Ахлах аудитор Д.Анхбаяр  
Анхан шатанд хянасан Менежер Ж.Энхцорол  
Хоёр дахь шатанд хянасан Дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ

Огноо: Огноо: Огноо:

Танилцаж зөвшөөрсөн: Засаг дарга Д.Лутгомөр  
СА-ы дарга С.Замандий

Огноо: Огноо:

6317144798  
ГЮА0048 319269



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-3259  
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 1574  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ Т

**ДАШИНЧИЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Д.ЛУТТӨМӨР ТАНАА**

ТАГ-аас танай сумын ХХС-гийн 2022 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийсэн дүгнэлт, тайланг хүргүүлж байна.

Аудитаар 106,075.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор бүрэн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана уу.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭ



006030309

ААБ 5.5: ДАШИНЧИЛЭН СУМЫН ХХСАНГИЙН АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Хүснэгт А. Эрсдэлтэй АГАДУТ-ын үнэлсэн алдаа, зөрчлийг шийдвэрлэх  
2023.03.25

Дд	АГАДУТ-ын ангид	АГАДУТ-ын дэд анги	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Материаллаг эсэх	Үр өгөөжөөр тооцох эсэх	Стандарт заалт	Шалгуур үзүүлэлт		Алдаа зөрчлийн ангилал	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Байгууллагын санал, тайлбар	Аудитын байгууллаг аас өгсөн хариу	Гаргасан шийдэл
								Хууль тогтоомжийн заалт	Шалгуур үзүүлэлт					
1	Ажил гүйцэтгэлийн анги	Нийт зардал	Өмнөх оны ХХС-ийн санхүүгийн тайлангийн аудитгаар гүйцэтгэг бүртгэгдээ цаг хугацааны дарааллаар зээлдэгчийн ХҮ, алданги, авлагаг тухай бүр нь бүртгэхгүй нийт дүнгээр нь дансны бичигт хийж бүртгэсэн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн боловч биелэгдээгүй, Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дүгээр захирамжаар баталсан НӨБББББ-ийг мөрдөж ажиллаагүй байна.	106,075,500.00	Материаллаг	Үгүй		Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан эгзэгд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитгаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитгаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" заалт	Хууль тогтоомжийн зарчмалтай холбоотой	Эрх бүхий албан тушаалтанд харууллага тооцуулах албан шаардлага хүргүүлэх.				Албан шаардлага
				106,075,500.00										

Бэлтгэсэн: Ахлах аудитор Д.Анхбаяр Огноо:   
 Анхан шатанд хянасан: Менежер Ж.Энхцолболт Огноо:   
 Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ Огноо:

Танилцаж зөвшөөрсөн: Засаг дарга Д.Лутгемер Огноо:   
 СА-ы дарга С.Замандий Огноо:

